



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 20 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/650.

Алтай хот

“Хүргэлт” нэгдсэн арга хэмжээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.12 дахь заалт, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотод оршин сууж байгаа нутгийн иргэд, их, дээд сургуульд суралцаж буй оюутан, залуучуудыг хүнсээр хангах, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор “Хүргэлт” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Хүргэлт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. “Хүргэлт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах хугацаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг малчид, иргэд олон нийтэд мэдээлж ажиллахыг хамтран хэрэгжүүлэгч байгууллагын дарга нарт, “Ковид-19” цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. “Хүргэлт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах явцад хяналт тавьж, зохион байгуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Л.Насанбуян)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

0301001892

11. Аймгийн Засаг даргын 2020 оны
 11 дугаар сарын 20-ны өдрийн 11 дугаар
 захирамжийн хавсралт



“ХҮРГЭЛТ” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН
 БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх
1.	Сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлэх	2020.11.20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Аймгийн Засаг даргын Тамгын газар
2.	Улаанбаатар хотруу хүнс илгээх иргэдийн судалгааг гаргах	2020.11.20-2020.11.23	Сумдын Засаг дарга нар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
3.	Улаанбаатар хотод хүнс хүлээн авах иргэдийн судалгааг гаргах	2020.11.20-2020.11.23	Сумдын Засаг дарга нар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
4.	Хүнс тээвэрлэх машины судалгааг гаргах	2020.11.20-2020.11.23	Сумдын Засаг дарга нар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
5.	Улаанбаатар хотод илгээмжийг иргэдэд хүргэх түгээлтийн багийг бүрдүүлэх	2020.11.20-2020.11.23	Сумдын Засаг дарга нар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
6.	Малчид хүнс, бэлтгэх ажлыг бэлэн болгох	2020.11.24	-	-
7.	Иргэдийн илгээмжийг хүлээн авч, бүртгэлжүүлэх	2020.11.23	Сумдын Засаг дарга нар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
8.	Мах, махан бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгох арга хэмжээг зохион байгуулах	2020.11.23	Сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг	Аймгийн Мал эмнэлгийн газар
9.	Хүнсний хүргэлтийг тээвэрлэсэн автомашины тээврийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж сумдаас нэгдсэн зохион байгуулалттайгаар гаргах	2020.11.23-2020.11.24	Сумдын Засаг дарга нар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
10.	Хүнсний хүргэлтийг тээвэрлэсэн автомашиныг заасан хугацаанд аймгийн төвд бэлэн байлгах	2020.11.26	Сумдын Засаг дарга	Хүнс, хөдөө аж ахуйн газар
11.	Хүнсний хүргэлтийг тээвэрлэх тээврийн хэрэгслийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж Улаанбаатар хотруу хөдөлгөх	2020.11.27	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар	Аймгийн Онцгой комисс
12.	Хүнсний хүргэлтийг Улаанбаатар хотод хүлээн авах, түгээх арга хэмжээг зохион байгуулах	2020.11.28-2020.11.30	Сумдын Засаг дарга, Түгээлтийн баг	Сумын Засаг даргын Тамгын газар
13.	Хүнс хүргэлтийг аяны тайланг нэгтгэн ирүүлэх	2020.12.01	Сумдын Засаг дарга	Хүнс, хөдөө аж ахуйн газар